

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР



ТАЛ ХЭЭРИЙН ЗАРИМ СУМЫГ ЦЕЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР ЗАГВАР
СУМ БОЛГОЖ, ХӨРСНИЙ ДОРОЙТЛЫГ БУУРУУЛАХ, УРЖИЛ ШИМИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛГООР БЭЛЧЭЭРИЙН ОЛОН НАСТ УРГАМАЛ ТАРИАЛАХ
/БАЯНЦАГААН СУМ 40 ГА/ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧ ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН
БАРИМТ БИЧИГ

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: ТӨАОНӨГ/202012084

Зуунмод сум
2020 он

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

БАТЛАВ.
ТӨВ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГА Ж.ДАШ-ЯЙЧИЛ

Огноо: 2020 оны 02 дугаар сарын 28

**ТАЛ ХЭЭРИЙН ЗАРИМ СУМЫГ ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР ЗАГВАР
СҮМ БОЛГОЖ, ХӨРСНИЙ ДОРОЙТЛЫГ БУУРУУЛАХ, УРЖИЛ ШИМИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛГООР БЭЛЧЭЭРИЙН ОЛОН НАСТ УРГАМАЛ ТАРИАЛАХ
/БАЯНЦАГААН СҮМ 40 ГА/ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧ ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН
БАРИМТ БИЧИГ**

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: ТӨАОНӨГ/202012084

Зуунмод сум
2020 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020-02-28

[Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар] нь тендерт оролцогдоос [тад хээрийн зарим сумыг цөлжилттэй тэмцэх чиглэлээр загвар сум болгож, хөрсний доройтлыг бууруулах, үргил шимийг нэмэгдүүлэх зорилгоор бэлчээрийн олон наст ургамал тариалах /Баянцагаан сум 40 га/ ажил]-ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэх цахим тендерт урьж байна.

Тендериин баримт бичгийг, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр Төрийн Худалдан Авах Ажиллагааны Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААНэгжийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ.

Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 mb, нэг файлын хэмжээ 15 mb, байна.

Цахим тендер зохион байгуулалт, журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 /тавин мянган/ төгрөгийг (www.tender.gov.mn)-ээр банкны Е-Меркантийн системийг ашиглан төлнө. Үнийн санал ирүүлэх материалын техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 15 цаг 00 минут-аас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn хаягаар ирүүлсэн байна.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан Зуунmod сумын 6-р /БаруунЗуунmod/ баг Төр, захиргааны 2 дугаар байр 2 давхар 201 тоот өрөө, Худалдан авах ажиллагааны алба 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 15 цаг 30 минут -д нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх. “Тооцно”.

Сонирхсон этгээд тендериин баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Төв аймаг, Зуунmod сум 6-р баг,
Орон нутгийн өмчийн газар,
Аймгийн Төр, Захиргааны 2 дугаар байр, 201 тоот өрөө,
Утас: 7027-3579,
Төрийн Худалдан Авах Ажиллагааны Цахим Систем
www.tender.gov.mn

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маятуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлгэдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

- 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэндэйг зөв гэж үзнэ;
- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцгчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу

гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь запруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТОӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТОӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвэл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

| ТОӨЗ-ны холбогдох заалт | A. Ерөнхий зүйл |
|--------------------------------|--|
| ТОӨЗ 1.1 | Захиалагч нь: [Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар] |
| ТОӨЗ 1.1 | Тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: Тал хээрийн зарим сумыг цөлжилттэй тэмцэх чиглэлээр загвар сум болгож, хөрсний доройтлыг бууруулах, үргжил шимийг нэмэгдүүлэх зорилгоор бэлчээрийн олон наст ургамал тариалах /Баянцагаан сум 40 га/ ажил Тендер шалгаруулалтын дугаар: ТӨАОНӨГ/202012084 |
| | B. Тендерийн баримт бичиг |
| ТОӨЗ 1.1 | Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: Төв аймаг, Зуунмод сум, 6-р баг, Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны алба, Утас: 702735-79 |
| ТОӨЗ 1.1 | Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын [0] хоногоос багагүй байна. |
| ТОӨЗ 1.1 | Санхүүжилтийн эх үүсвэр: 2020 оны аймгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын эх үүсвэрээр Төсөвт өртөг: 48,000,000 төгрөг |
| | C. Тендер бэлтгэх |
| ТОӨЗ 1.1 | Хэрэв тендерт гадаадын этгээд оролцох эрхтэй: эрхгүй Тендерийн хэл нь Монгол хэл байна. |
| ТОӨЗ 1.1 | Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ.Үүнд: Тендерт оролцогч хуулийн этгээд нь <ul style="list-style-type: none"> - Унийн санал /маягтын дагуу/ - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар - Байгууллагын танилцуулга /4-өөс доошгүй жил үйл ажиллагаа эрхэлсэн ажилласан туршлагын мэдээлэл, холбогдох нотлох баримтыг хамт/ - Тендер нээсэн өдрийн байдлаар татварын өр, төлбөргүй байх /татварын цахим системээс авсан бар код бүхий тодорхойлолт ирүүлнэ./ - Тендер нээсэн өдрийн байдлаар Нийгмийн даатгалын санд |

| | |
|--|--|
| | <p>өр, төлбөргүй байх /харьяа Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ./</p> <ul style="list-style-type: none"> - Тендер нээсэн өдрийн байдлаар харилцах банк, холбогдох байгууллагад хугацаа хэтэрсэн өр, зээлгүй, зээлийн батлан даалтын гэрээгээр хүлээсэн өр төлбөргүй байх / харилцагч банк шүүх мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт ирүүлнэ./ - Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэл гаргаж ирүүлнэ. - Тендерт оролцогчийн үнийн саналыг олон нийтэд мэдээллэхэд татгалзах зүйлгүй тухай мэдэгдлийг ирүүлнэ. - Гэрээний нөхцөл, тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн албан мэдэгдлийг ирүүлнэ. - Татвар, Нийгмийн Даатгал, Шүүх, Банк, ШШГБайгууллагаас тендерийн бичиг баримттай холбоотой асуудлаар тодорхойлолт, лавлагаа гаргуулахад тендерт оролцогч татгалзах зүйлгүй гэсэн мэдэгдлийг тендерийн баримт бичигт хавсаргаж ирүүлнэ. - Тендерт оролцогч олон багц ажлын тендерт оролцох болон хэрэгжүүлж байгаа буюу хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл, тус гэрээнд ажиллаж байгаа, ажиллуулах голлох инженер, техникийн ажилтан, ажилчид, машин механизмын, багаж хэрэгсэл нь 3 хүртэл ажил, үйлчилгээнд давхцан ажиллах боломжтой бөгөөд тендерт санал болгосон голлох инженер, техникийн ажилтан, ажилчид, машин механизмын, багаж хэрэгсэл нь 2 ба түүнээс дээш ажил /хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэх эрх авсан тендерт шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх авах тендерийн багц хамаарна/-д давхардсан тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно. - Тендерт оролцогч нь тендер нээсэн өдрийн байдлаар гэрээ хэрэгжүүлж байгаа болон гэрээ байгуулах эрх авсан талаарх мэдээллийг албан бичгээр гаргаж ирүүлэх үүрэгтэй. - Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар / нотариатаар баталгаажуулсан байх/ - Эвдэрсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын гэрчилгээ - Таримал ургамлын үр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл - Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын даалгавар зураг, төсвийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн бараа, ажил, үйлчилгээг дуусгаж ашиглалтанд хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.3 - Ажил гүйцэтгэх нарийвчилсан хугацааны графикийг /маягтын дагуу/ ирүүлнэ. Мөн аргачлалыг боловсруулан ирүүлнэ. <p>ТШӨХ-н 1.1-д заасан өгөгдөл, шаардлагын аль нэгийг хангаагүй эсхүл дээр заасан тодорхойлолтууд, баримт бичгүүдээс аль нэгийг</p> |
|--|--|

| | <p>нь ирүүлээгүй, ирүүлсэн баримт бичиг нь заасан нөхцөл, шалгуурыг хангахгүй, хуурамч, эсхүл сүүлийн 3 жилд нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний чанар хангалтгүй байсан нь өмнөх захиалагч байгууллагудын тодорхойлолтоор болон хяналт шалгалтын байгууллагын хяналтаар нотлогдсон зэрэг тохиолдолд тендерээс татгалзаж, хуурамч нотлох баримт ирүүлсэн нь нотлогдсон нөхцөлд тендерт орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгүүлэхээр эрх бүхий байгууллагад хандана.</p> | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|-----------------|--|--|--------------|--|--------------|-------------------------------|---|--|--|--|--|------|--|--|--|--|-----|--|--|--|--|
| ТОӨЗ 1.1 | <p>Ижил төстэй ажил, үйлчилгээ гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 5 жил буюу 2015, 2016, 2017, 2018, 2019 онуудад хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалтыг ирүүлнэ.</p> <p>Ижил төстэй ажил, үйлчилгээнд: олон наст ургамал тариалах, биологийн нөхөн сэргээлт хийсэн ажил байна.</p> <p>Сүүлийн 5 жил буюу 2015, 2016, 2017, 2018, 2019 онуудад нийт төсөөт өртгийн 100 хувиас багагүй хэмжээний ижил төстэй ажил гүйцэтгэсэн байна. Мөн онуудад Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон сумдын Засаг даргын Тамгын газартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажилласан бол гэрээний үүргийн гүйцэтгэлийн талаарх албан бичгийг ирүүлнэ.</p> <p>Ажил хүлээлгэж өгсөн улсын комиссын актыг хавсаргана.</p> | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | <table border="1"> <thead> <tr> <th>№</th><th>Гэрээний нэр</th><th>Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс</th><th>Төсөөт өртөг</th><th>Дууссан, эсхүл дуусах хугацаа</th></tr> </thead> <tbody> <tr> <td>1</td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr> <td>....</td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr> <td>ДҮН</td><td></td><td></td><td></td><td></td></tr> </tbody> </table> | № | Гэрээний нэр | Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс | Төсөөт өртөг | Дууссан, эсхүл дуусах хугацаа | 1 | | | | | | | | | | ДҮН | | | | |
| № | Гэрээний нэр | Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс | Төсөөт өртөг | Дууссан, эсхүл дуусах хугацаа | | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| ДҮН | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| ТОӨЗ 1.1 | <p>Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: “Шаардлагагүй” 2018, 2019 онуудын борлуулалтын орлогын нийлбэр нь төсөөт өртгийн 30 хувиас багагүй байна.</p> <p>2018, 2019 оны санхүүгийн тайлан сангийн яамны e-balance цахим бүртгэлд шивэгдэж баталгаажсан байх шаардлагатай, санхүүгийн тайлан бүртгэлд шивэгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p> | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| ТОӨЗ 1.3 | <p>Гэрээг гүйцэтгэхээд зайлшгүй шаардлагатай ажиллах хүч: Мэргэжилтэй ажилчдын диплом, мэргэжлийн үнэмлэхийн хуулбар. Удирдах болон инженер техник, мэргэжилтэй ажилчид нь тухайн байгууллагын үндсэн ажилчин байх бөгөөд ажилладаг талаар нотлох нийгмийн даатгалын дэвтэрийн хуулбарын хамт хавсаргаж ирүүлнэ. Гэрээт ажилд ашиглах өөрийн эзэмшлийн машин механизмын, тоног төхөөрөмжийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг нотариатаар</p> | | | | | | | | | | | | | | | | | | | | |

| | |
|-------------------|--|
| | баталгаажуулж ирүүлнэ. |
| ТОӨЗ 1.4 | Тендер ирүүлэхийн өмнө уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй” |
| ТОӨЗ 1.5 | Хувилбарт тендер ирүүлэхийг “Зөвшөөрөхгүй” |
| ТОӨЗ 1.6 | Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад “ <i>Toхируулахгүй тогтмол байна</i> ” |
| ТОӨЗ 1.7 | Тендерийн валют” “ <i>Төгрөг байна.</i> ” <i>Урьдчилгаа төлбөр төлөхгүй.</i> |
| ТОӨЗ 1.8 | Тендер нээнээс хойш 30 хоногийн туршид хүчинтэй байна. |
| ТОӨЗ 1.9 | Тендерийн баталгааны дүн: “ <i>Шаардахгүй</i> ” |
| ТОӨЗ 1.10 | Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: <i>шаардлагагүй</i> |
| | Г. Тендер ирүүлэх |
| ТОӨЗ 2.1 | Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Цаг: [15 цаг 00 минут] Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй. |
| | Д. Тендерийг нээх, үнэлэх |
| ТОӨЗ 2.1 | Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: Төв аймаг Зуунмод сум Төр, Захиргааны 2 дугаар байр, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны алба Давхар болон өрөөний дугаар: 2 давхарт, 201 тоот өрөө Аймаг, хот: Төв аймаг Зуунмод хот Улс: Монгол Улс Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Цаг: 15 цаг 30 минут |
| ТОӨЗ 2.2.3 | Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Унийн санал /маягтын дагуу/ - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар - Байгууллагын танилцуулга /4-өөс доошгүй жил үйл ажиллагаа эрхэлсэн ажилласан туршлагын мэдээлэл, холбогдох нотлох баримтыг хамт/ - Тендер нээсэн өдрийн байдлаар татварын өр, төлбөргүй байх /татварын цахим системээс авсан бар код бүхий тодорхойлолт/ - Тендер нээсэн өдрийн байдлаар Нийгмийн даатгалын санд өр, төлбөргүй байх /харьяа Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт/ - Тендер нээсэн өдрийн байдлаар харилцах банк, холбогдох байгууллагад хугацаа хэтэрсэн өр, зээлгүй, зээлийн батлан даалтын гэрээгээр хүлээсэн өр төлбөргүй байх / харилцагч |

| | |
|--|--|
| | <p>банк шүүх мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт/</p> <ul style="list-style-type: none"> - Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэл - Тендерт оролцогчийн үнийн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай мэдэгдлийг ирүүлнэ. - Гэрээний нөхцөл, тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн албан мэдэгдлийг ирүүлнэ. - Татвар, Нийгмийн Даатгал, Шүүх, Банк, ШШГБайгууллагаас тендерийн бичиг баримттай холбоотой асуудлаар тодорхойлолт, лавлагаа гаргуулахад тендерт оролцогч татгалзах зүйлгүй гэсэн мэдэгдэл - Тендерт оролцогч олон багц ажлын тендерт оролцох болон хэрэгжүүлж байгаа буюу хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл, тус гэрээнд ажиллаж байгаа, ажиллуулах голлох инженер, техникийн ажилтан, ажилчид, машин механизмын, багаж хэрэгсэл нь 3 хүртэл ажил, үйлчилгээнд давхцан ажиллах боломжтой бөгөөд тендерт санал болгосон голлох инженер, техникийн ажилтан, ажилчид, машин механизмын, багаж хэрэгсэл нь 2 болон түүнээс дээш ажил /хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэх эрх авсан тендерт шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх авах тендерийн багц хамаарна/-д давхардсан тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно. - Тендерт оролцогч нь тендер нээсэн өдрийн байдлаар гэрээ хэрэгжүүлж байгаа болон гэрээ байгуулах эрх авсан талаарх мэдээллийг албан бичгээр гаргаж ирүүлэх үүрэгтэй. - <i>Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар / нотариатаар баталгаажуулсан байх/</i> <ul style="list-style-type: none"> - Эвдэрсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын гэрчилгээ - Таримал ургамлын үр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл - Ижил төстэй ажил, үйлчилгээ гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: <i>Сүүлийн 5 жил буюу 2015, 2016, 2017, 2018, 2019 онуудад хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалт</i> <p>Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын зураг, төсвийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн бараа, ажил, үйлчилгээг дуусгаж ашиглалтанд хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Ажил гүйцэтгэх нарийвчилсан хугацааны графикийг /маягтын дагуу/ ирүүлнэ. Мөн аргачлалыг боловсруулан ирүүлнэ. <p>Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг</p> |
|--|--|

| | |
|--|--|
| | <p>хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж/ файл үүсгэж ирүүлнэ. Тус хавтасны/ файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Нууцлахгүй ирүүлэхээр шаардсан материалыг худалдан авах ажиллагааны цахим системд “нууц эсэх- тийм” байхаар ирүүлсэн тохиолдолд тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</p> |
| | Е. Гэрээ байгуулах эрх олгох |

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Ажлын даалгаврыг цахим системийн ТЭЗҮ хэсэгт нийтэлсэн болно.

Тав. ЗУРАГ

Зургийн санамж

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

| Д/Д | Хийгдэх ажил | Сар | 04 сар | | | 05 сар | | | | | | Дүн /төгрөгөөр/ |
|---------------------------|--------------|------------|--------|---|----------------|--------|---|---|---|---|---|--|
| | | 10 хоног | 1 | 2 | 3 | 1 | 2 | 3 | 1 | 2 | 3 | |
| 1 | | Төлөвлөгөө | | | Мөнгөн дунгээр | | | | | | | |
| | | гүйцэтгэл | | | | | | | | | | |
| | | Төлөвлөгөө | | | | | | | | | | |
| | | гүйцэтгэл | | | | | | | | | | |
| | | Төлөвлөгөө | | | | | | | | | | |
| | | гүйцэтгэл | | | | | | | | | | |
| | | Төлөвлөгөө | | | | | | | | | | |
| | | гүйцэтгэл | | | | | | | | | | |
| | | Төлөвлөгөө | | | | | | | | | | |
| | | гүйцэтгэл | | | | | | | | | | |
| | | Төлөвлөгөө | | | | | | | | | | |
| | | гүйцэтгэл | | | | | | | | | | |
| | | Төлөвлөгөө | | | | | | | | | | |
| | | гүйцэтгэл | | | | | | | | | | |
| | | Төлөвлөгөө | | | | | | | | | | |
| | | гүйцэтгэл | | | | | | | | | | |
| | | Төлөвлөгөө | | | | | | | | | | |
| | | гүйцэтгэл | | | | | | | | | | |
| | | Төлөвлөгөө | | | | | | | | | | |
| | | гүйцэтгэл | | | | | | | | | | |
| Бүгд дүн /сая,төг/ | | | | | | | | | | | | Санал болгож буй тендерийн үнэ бичигдэнэ. |

Долоо. ЖИШИГ МАЯГТ

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендериин үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана. 4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна. 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдолын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. |

Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

- | | |
|---|--|
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана. |
| 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх | 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. |
| 11. Үе шатны ажлын хуваарь | 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна. |

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- | | |
|---|--|
| 11. Үе шатны ажлын хуваарь | 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарь тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна. |
| 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх | 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ. |
| 13. Алданги | 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарь нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй. |
| | 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги ² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. |

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

| | |
|--|---|
| 14. Ажил дуусгах | 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна. |
| 15. Хүлээж авах | 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна. |
| 16. Эцсийн тооцоо | <p>16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.</p> <p>Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.</p> <p>Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай запруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.</p> |
| 17. Ашиглалт, засвар, үйлчилгээн ийг гарын авлага | <p>17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.</p> <p>17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.</p> |
| 18. Гэрээг цуцлах | <p>18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.</p> <p>18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:</p> <p>(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;</p> |

- (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
- (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
- (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
- (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

20. Гүйцэтгэлээс чөлөөлөх

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

| | |
|-----------------|--|
| ГЕН 2.1 | Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>[Тал хээрийн зарим сумыг цөлжилттэй тэмцэх чиглэлээр загвар сум болгож, хөрсний доройтлыг бууруулах, үржил шимиийг нэмэгдүүлэх зорилгоор бэлчээрийн олон наст ургамал тариалах /Баянцагаан сум 40 га/ ажил ажил- ТӨАОНӨГ/202012084]</i> |
| ГЕН 2.1 | <p>Ажил нь <i>[цахим системд нийтэлсэн ажлын даалгавраас]</i>-аас бүрдэнэ.</p> <p>Ажлын талбай нь <i>[Төв аймгийн Зуунмод суманд]</i>-д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.</p> |
| ГЕН 3.1 | Төслийн менежер нь <i>[захиалагч байгууллагаас томилогдсон этгээд байна.]</i> |
| ГЕН 4.1 | <p>Ажил эхлэх өдөр <i>[2020.04.06]</i></p> <p>Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>[2020.05.06]⁴</i></p> |
| ГЕН 7.1 | Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <i>[5]</i> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана. |
| ГЕН 9.1 | Чанарын баталгаат хугацаа <i>[.....]</i> хоног байна. |
| ГЕН 13.1 | <p>Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>[0,05]</i> байна.⁵</p> <p>Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>[10]</i> байна.</p> |
| ГЕН 17.1 | <p>Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <i>[огноо]</i>-ны дотор гаргаж өгнө.</p> <p>Гүйцэтгэлийн зургийг <i>[огноо]</i>-ны дотор гаргаж өгнө.</p> <p>Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <i>[мөнгөн дүн]</i> байна.</p> |
| ГЕН 19.1 | Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <i>[хувь]</i> -иар тооцно. |

³ Захиалагч төндерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁴ Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.

⁵ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

| | |
|-----------------|-----------------|
| (Тамга, тэмдэг) | (Тамга, тэмдэг) |
| (Гарын үсэг) | (Гарын үсэг) |
| (Албан тушаал) | (Албан тушаал) |

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20... онд: _____ төгрөг; 20... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан,

цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын
усэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын
усэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]